



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 4/26

Арвайхээр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэг, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйл, Зөрчлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.19 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийн хэрэгжилтийг сайжруулах талаар хийх ажлын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөний хэрэгжилийг хангах арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж ажиллахыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн татварын улсын байцаагч (Р.Наранчулуун)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн дарга (С.Дашхорол)-д үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГ

Н.ЭРДЭНЭСУВД



Өвөрхангай аймгийн Татварын хэлтсийн  
даргын 2022 оны 28 сарын 29-ны өдрийн  
4/18 дүгээр тушаалын хавсралт

ЙЮА0056  
1116128579 51 0044027

**2022 ОНД НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРЫН ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТИЙГ САЙЖРУУЛАХ ТАЛААР ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Хэрэгжүүлэх ажил	Хугацаа	Хариуцах албан хаагч
1	Төлбөрийн баримт шивж орлого олсон иргэдийн судалгаагааг гаргаж албан хаагч нарт хүргүүлэх	1 сард	Р. Наранчулуун
2	Дээрхи судалгаанд орсон иргэдээс "Хувь хүний орлогын албан татварын тайлан"-г тайлагнуулан, хүлээн авах, татварт хамруулан төлөлтийг барагдуулах	2 сард	С.Оюун-эрдэнэ С.Уранцэцэг Б.Батдолгор Сумдын байцаагч, хураагчид
3	Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөгдөх бараа, ажил үйлчилгээний талаархи сургалтыг ажилтнуудад хийх, танхимаар, цахимаар	3 сард	Ц. Даваасүрэн
4	Төлбөрийн баримт олгоогүй гомдол гаргасан иргэдээс ирсэн гомдлыг холбогдох хуулийн дагуу шалган зөрчил илэрсэн тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага тооцох	Тухай бүр	Бүх байцаагч нар
5	Тогтмол үйл ажиллагаа явуулдаг иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгааг сум бүрээр гаргуулан авах	3 сард	Сум хариуцсан байцаагчид Р. Наранчулуун
6	Үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын судалгаанд үндэслэн ТУНС-ээс цахим төлбөрийн баримт олголтыг шалгах	3 сард	Я. Наранчимэг Р. Наранчулуун
7	Дээрхи судалгаанд үндэслэн ТУНС-ээс шалгаж цахим төлбөрийн баримт олгоогүй, дутуу олгосон иргэн, аж ахуйн нэгж байгууллагын шалтгаан нөхцлийг тодруулан санаатай олгоогүй, дутуу олгосон газарт харицлага тооцон, цаашид тогтмол олгож байхыг зөвлөх	Хуваарийн дагуу	Бүх байцаагч нар
8	Арвайхээр суманд үсчин, гоо сайхан, засвар, үйлчилгээний үйл ажиллагаа явуулж буй татвар төлөгчдөд QR бүхий баримт олголтын наалт бүрэн наасан эсэхэд хяналт тавих, бүртгэл хөтлөн танилцуулах	3-6 сард	С.Оюун-эрдэнэ С.Уранцэцэг Б.Батдолгор
9	Эрүүл мэндийн үйлчилгээ явуулах тусгай зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрөл сунгах журамтай танилцаж, ямар шаардлага тавигддаг эсэхийг судлан, төлбөрийн баримтын талаархи санал оруулах	4 сард	Р.Наранчулуун Я.Наранчимэг

10	Мал эмнэлэгийн үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад QR бүхий баримт олголтын наалт олгох	5 сард	Бичил татвар төлөгчтэй харилцах тасгийн байцаагчид
11	Орон сууцны зориулалттай барилга барьж, борлуулж байгаа иргэн, ААНБ-ын судалгааг гарган худалдан авсан иргэдэд төлбөрийн баримт олгох талаар биечлэн сургалт зохион байгуулах	Тухай бүр	С.Оюун-эрдэнэ С.Уранцэцэг Б.Батдолгор Р. Наранчулуун Я. Наранчимэг
12	Төсвийн тухай хууль өөрчлөгдсөнтэй холбоотой татварын орлого тухайн орон нутагт төвлөрүүлэхийн тулд төлбөрийн баримт олголтын системд тохиргоо хийх талаар зөвлөгөө мэдээлэл өгөх, албан бичиг хүргүүлэх	3 сард	Бүх албан хаагч нар
13	Үсчин, гоо сайхны салоны газраас төлбөрийн баримтаа хэрхэн авах талаар лайв хийж сурталчилах	5 сард	Ц.Даваасүрэн Л.Буянжаргал
14	Төлбөрийн баримт сайн олгодог татвар төлөгчдийг урамшуулах зорилгоор FRAME хийж, зураг авч, сурталчлах	6 сард	Б.Батдолгор Х.Түвшин
15	Төлбөрийн баримт сайн олгодог татвар төлөгчдийг урамшуулах зорилгоор Хэлтсийн пэйж хуудасаар LIVE хийх	5 сард	Л.Буянжаргал
16	Төлбөрийн баримт сайн олгодог татвар төлөгчдийг урамшуулах зорилгоор Орон нутгийн телевизээр сурталчилах	6 сард	Ц.Даваасүрэн
17	Аж ахуйн нэгж байгууллагаар тогтмол үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийг ТУНС-ээс шалган нэг ч баримт олгоогүй судалгааг гаргаж сургалт зохион байгуулах	9 сард	Р. Наранчулуун Я. Наранчимэг Ц.Даваасүрэн Л.Буянжаргал
18	Төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан албан хаагч нараар хангуулахад анхаарч ажиллах, тухайн цаг үеийн тайланг хэлтсийн даргад танилцуулах	Сар бүр	Р. Наранчулуун